

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй
төсөл арга хэмжээ гэрээний хугацаанд хэрэгжээгүй,
захиалагчийн хяналт хангалтгүй байна.

АУДИТЫН НЭР: УЛСЫН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ГНАГ-2024/18-ШТА-ГА

Улиастай сум
2024 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа
Утас: 7046-3612, Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn
Аудитын менежер Х.Болдбаатар
Утас: 7046-3783, Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Жалбаа
Утас: 89330330, Цахим хаяг: jalbaab@audit.gov.mn
Аудитор Д.Пүүжмаа
Утас: 99080797
Цахим хаяг: puujmaad@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу:
Цахим хуудас www.audit.mn

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР.....	2
ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ.....	2
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ.....	3
БҮЛЭГ А. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХОЛБОГДОХ ТООЦООЛОЛ, БАРИМТ БИЧИГ НЬ ЗУРАГ ТӨСЛИЙН МАГАДЛАЛЫН ДҮГНЭЛТЭЭР БАТАЛГААЖСАН БАЙНА.....	4-7
- Материалын үнийн өсөлтийн зөрүү олгосон төсөл арга хэмжээнүүдэд магадлал хийгдсэн байна. - Өмнөх оноос дамжин хэрэгжих төсөл арга хэмжээг 2023 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад бүрэн тусгаагүй байна. - Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгагдаж, эрх шилжсэн 18 төсөл арга хэмжээний 17 нь материалын үнийн өсөлтийн зөрүү олгохоор батлагдсан байна.	
БҮЛЭГ Б. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ АНХНЫ ГЭРЭЭНИЙ ХУГАЦААНД БҮРЭН ГҮЙЦЭТГҮҮЛЖ, ХҮЛЭЭН АВААГҮЙ БАЙНА.....	8-20
- Төсөл арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь хэрэгжүүлээгүй байна - Барилгын ажлын гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналт хангалтгүй, улсын комиссоос өгсөн үүрэг даалгавар хэрэгжээгүй байна. - Улсын комисс хүлээн авсан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаагүй байна.	
БҮЛЭГ В. ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ НЬ ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНД ХҮРЧ, ОРОН НУТГИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГАД НИЙЦСЭН БАЙНА.....	21
ДҮГНЭЛТ.....	22
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ.....	23
ЗӨВЛӨМЖ:.....	24
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ.....	25-30
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТАЙЛБАР.....	31

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХБТХО	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалт

ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	2021, 2022 онд улсын комисс хүлээн авч, үнийн зөрүү олгогдсон төсөл арга хэмжээний жагсаалт	5
2	Барилга угсралтын ажил дутуу, өмнөх оноос дамжин хэрэгжиж, үнийн зөрүү олгогдсон төсөл арга хэмжээний жагсаалт	6
3	Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан хөрөнгийн нэгтгэл	7
4	Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний ажилд хэрэгжүүлсэн хяналтын мэдээлэл	17
5	Улсын комисс хүлээн авсан төсөл арга хэмжээг данс бүртгэлд тусгасан мэдээлэл	20

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт арга зүй**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 8 дугаар тогтоолд тусгасны дагуу аудитыг хийж гүйцэтгэсэн.

Аудитын зорилт

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан дүнг Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн эсэх
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж хүлээн авсан эсэх
- Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх

Аудитын хамарсан хүрээ

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн ТЕЗ, аймгийн ГХБХБГ, Орон нутгийн өмчийн газар, ЗДТГ-ын дэргэдэх ХБТХО-ын хэлтэс, тэдгээрийн холбогдох албан тушаалтан, мэргэжилтнүүд, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг гүйцэтгэгч компаниуд, ашиглагч байгууллагуудыг хамруулан, төсөл арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд аудитыг хийж гүйцэтгэсэн.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ашигласан.

Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа, аудитын менежер Х.Болдбаатар нар хянан удирдаж, ахлах аудитор Б.Жалбаа, аудитор Д.Пүүжмаа нар 2024 оны 01 дүгээр сарын 19-өөс эхлэн 2024 оны 04 дүгээр сарын 19-ний хооронд хийж гүйцэтгэлээ.
Хүндрэл бэрхшээл	Аудитыг гүйцэтгэх явцад өвөл цас их орж замын нөхцөл байдал хүндрэн, зам даваа нээгдээгүйгээс зарим төсөл арга хэмжээг бодит байдалд үзэх боломжгүй байлаа. Мөн улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээг цахим бүртгэлд шилжүүлж, сангийн яамны https://pimis.publicinvestment.gov.mn/ программд мэдээллийг 2022 оноос эхлэн оруулсан байна. Гэтэл уг программд аудитад шаардлагатай мэдээллийг бүрэн оруулаагүй нь аудит хийхэд хүндрэлтэй байлаа.

Аудитын ерөнхий мэдээлэл

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад Завхан аймагт хэрэгжүүлэхээр 127,802.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 40 төсөл арга хэмжээ батлагдсан байна. Үүнээс 70,382.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 төсөл арга хэмжээ орон нутагт эрх шилжсэн, 57,420.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 22 төсөл арга хэмжээ эрх шилжээгүй байна.

Орон нутагт эрх шилжсэн 18 төсөл арга хэмжээнд 2023 онд 8,606.5 сая төгрөгийн санхүүжилт олгохоор батлагджээ

Зорилт 1. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичиг нь зураг төслийн магадлалын дүгнэлтээр баталгаажсан байна.

А.1 Материалын үнийн өсөлтийн зөрүү олгосон төсөл арга хэмжээнүүдэд магадлал хийгдсэн байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч Монгол улсын 2023 оны төсвийн төсөлд 53 төсөл арга хэмжээ тусгах санал хүргүүлснээс Завхан аймагт 2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих төсөл арга хэмжээ батлагдаагүй байна.

Харин 2023 оны төсвийн тухай хуульд өмнөх оноос дамжин хэрэгжих 40 төсөл арга хэмжээ батлагдсанаас 18 төсөл арга хэмжээ орон нутагт эрх шилжжээ. Дэлгэрэнгүй судалгааг тайлангийн хавсралтаас үзнэ үү. [Sudalgaanii mayagt 2023 oni UTHO.xlsx](#)

Үүнээс 6 төсөл арга хэмжээ нь 2023 онд зөвхөн материалын үнийн өсөлтийн зөрүү олгогдсон бөгөөд 2021, 2022 онд улсын комисс хүлээн авсан ажлууд байна. Эдгээр нь УИХ-ын 2021 оны 88 дугаар тогтоолд үндэслэн барилгын хөгжлийн төвөөр магадлал хийлгэсэн төсөл арга хэмжээнүүд байна.

Хүснэгт 1. 2021, 2022 онд улсын комисс хүлээн авч,
үнийн зөрүү олгогдсон төсөл арга хэмжээний жагсаалт

/сая.төг/

д/д	Төсөл арга хэмжээний нэр	Анхны гэрээний дүн	Материалын үнийн өөрчлөлтийн зөрүү	Зураг төслийн магадлалын дүгнэлтийн дугаар	Улсын комисс хүлээн авсан он
1	Засаг даргын Тамгын газрын барилга /Түдэвтэй сум/	1,194.9	274.2	88-0329/2022	2021
2	Засаг даргын Тамгын газрын барилга /Ургамал сум/	1,198.1	262.7	88-137/2022	2021
3	Цэцэрлэгийн барилга /Цэцэн-Уул сум/	1,495.2	364.5	88-366/2022	2021
4	Нисэх буудлын авто замын уулзвараас сумын төв хүртэлх авто зам 6.7 км сумын төвийн хатуу хучилттай авто зам /Алдархаан сум/	5,314.1	74.1	Аудитад ирүүлээгүй	2022
5	Сумын төвийн шинэчлэл /Алдархаан сум/	4,885.0	49.3	88-463/2022	2022
6	Гудамж төсөл /Улиастай сум/	9,791.9	90.8	199/2022-УИХ88	2022
ДҮН		23,879.2	1,115.6		

Эдгээр төсөл арга хэмжээтэй холбоотой өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийн талаар аудитын тайлангийн Б.2 хэсэгт тусгасан болно.

А.2 Өмнөх оноос он дамжин хэрэгжих төсөл арга хэмжээг 2023 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад бүрэн тусгаагүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын өмнөх оны жагсаалтад орхигдсон Шилүүстэй сумын засаг даргын тамгын газрын барилга, Асгат сумын дотуур байрын барилга, Идэр сумын сургууль, спорт заалны барилга, Сонгино сумын сургууль, спорт заалны барилга, Тэлмэн сумын сургуулийн барилга, спорт заалны барилга, Баянхайрхан сумын хүүхдийн цэцэрлэгийн барилга зэрэг 6 төсөл арга хэмжээнээс 2023 оны төсөл арга хэмжээний жагсаалтад 5 төсөл арга хэмжээ нь батлагдаж, Баянхайрхан сумын хүүхдийн цэцэрлэгийн барилга дахин орхигдсон байна.

Баянхайрхан сумын цэцэрлэгийн барилгын ажил 2021 оноос хойш бүрэн зогссон байна. Ажил зогссон талаар захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагаас тайлбар тодруулга авахад материалын үнийн өөрчлөлтийг тооцуулан магадлалын дүгнэлт гаргуулаагүй тул 2023 оны төсөвт санхүүжилт батлагдаагүй байна. Харин 2020 онд хийгдсэн анхны төсөвтөө дахин магадлал хийлгүүлж 887.0 сая төгрөг 2024 оны төсөвт батлагдсан байна. Уг төсөл арга

хэмжээ нь 1,477.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд санхүүжилтийг 2020, 2021 онуудад бүрэн олгосон, гүйцэтгэл 80 орчим хувьтай байна.



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээг гэрээний хугацаанд хэрэгжүүлээгүйгээс өмнө нь хийсэн ажилд эвдрэл гэмтэл гарч, нэмэлт хөрөнгө шаардагдах нөхцөлийг бий болгож байна.

А.3 Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгагдаж, эрх шилжсэн 18 төсөл арга хэмжээний 17 нь материалын үнийн өсөлтийн зөрүү олгохоор батлагдсан байна.

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгагдсан эрх шилжсэн 18 төсөл арга хэмжээний 6 нь улсын комисс хүлээн авч материалын үнийн зөрүү олгогдсон, 11 төсөл арга хэмжээ нь ашиглалтад оруулаагүй бөгөөд материалын үнийн өсөлтийн зөрүү тусгагдсан, зөвхөн 1 төсөл арга хэмжээнд гүйцэтгэлийн санхүүжилт олгосон байна.

Барилга угсралтын ажлын гүйцэтгэл дутуу 11 төсөл арга хэмжээний төсвийг барилгын хөгжлийн төвийн магадлалд үндэслэсэн баталжээ.

Хүснэгт 2. Барилга угсралтын ажил дутуу, өмнөх оноос дамжин хэрэгжиж, үнийн зөрүү олгогдсон төсөл арга хэмжээний жагсаалт
/сая.төг/

д/д	Төсөл арга хэмжээний нэр	2023 онд санхүүжигдэх дүн	Санхүүжилт олголт %	Зураг төслийн магадлалын дүгнэлтийн дугаар
1	Хөгжимт жүжгийн театрын барилга, суудалтай /Улиастай/	800 513.2	100	88-0418/2022
2	Соёлын төвийн барилга /Түдэвтэй/	333.2	50.53	88-0015/2022
3	Соёлын төвийн барилга /Нөмрөг сум/	411.8	100	88-419/2022
4	Сургуулийн барилга, спорт заал, суудал /Сонгино сум/	320 1,276.7	100	88-338/2022
5	Сургуулийн барилга, спорт заал, суудал /Тэлмэн сум/	320 809.7	100	88-0083/2022
6	Сургуулийн барилга, спорт заал, суудал /Идэр сум/	320 1,074.7	54.7	88-437/2022
7	Цэцэрлэгийн барилга /Тосонцэнгэл сум/	293.9	100	88-0155/2022
8	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, км /Их-Уул сум/	3 26.7	100	269/2022-УИХ88

9	Засаг даргын тамгын газар /Шилүүстэй сум	218.5	90	88-110/2022
10	Жавхлант цогцолбор сургуулийн 2 дугаар байрны барилга /Улиастай/	387.8	100	88-213/2022
11	Дотуур байрын барилга /Асгат сум	263.7	76	Аудитад ирүүлээгүй

Эдгээрээс зарим төсөл арга хэмжээний санхүүжилт дутуу олгогдсон байгаа нь барилгын барьцаа хөрөнгийн дансанд байршуулсантай холбоотой байна.

Аймгийн төрийн сан дахь барилгын ажлын барьцаа хөрөнгийн дансанд 6 төсөл арга хэмжээний 1,102.7 сая төгрөгийн санхүүжилтийн үлдэгдлийг байршуулжээ.

Хүснэгт 3. Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан хөрөнгийн нэгтгэл /сая.төг/

д/д	Төсөл арга хэмжээний нэр	Мөнгөн дүн
1	Засаг даргын тамгын газрын барилга /Шилүүстэй сум/	21.8
2	Дотуур байрын барилга, 75 ор /Асгат сум/	63.7
3	Сургуулийн барилга, спорт заал 320 суудал /Идэр сум/	486.5
4	Цэцэрлэгийн барилга /Тосонцэнгэл сум/	76.1
5	Дотуур байрын барилга, 100 ор /Цэцэн-Уул сум/	289.8
6	Соёлын төвийн барилга, 200 суудал /Түдэвтэй сум/	164.8
	ДҮН	1,102.7

Харин Цэцэн-Уул суманд баригдсан хүүхдийн дотуур байрны барилгын санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн 84.6 хувийг олгож, зөрүү хөрөнгийг барилгын барьцаа хөрөнгийн дансанд байршуулжээ.

Төсвийн тухай хуульд эрх шилжсэн 18 төсөл арга хэмжээний санхүүжилтэд 8,606.5 сая төгрөг батлагдсан байхад гүйцэтгэлээр улсын төсвөөс 9,317.5 сая төгрөгийн санхүүжилт олгогдож, батлагдсан төсвөөс 711.0 сая төгрөг илүү байна. Энэ нь Соёлын сайд төсөвт зохицуулалт хийж Нөмрөг сумын соёлын төвийн барилгын ажилд 635.0 сая төгрөгийн санхүүжилтийг, Тосонцэнгэл сумын цэцэрлэгийн барилгын ажилд өмнөх онд зохицуулалтаар олгогдоогүй 76.1 сая төгрөгийн үлдэгдлийг тус тус олгосонтой холбоотой байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдан, эрх шилжин хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдэд олгосон санхүүжилтийг ажил эхэлсэн хугацаанаас хөөн тулгахад Түдэвтэй суманд баригдсан Засаг даргын Тамгын газрын барилгын гүйцэтгэгчид техник хяналтын зардал 9.2 сая төгрөгийг суутган тооцолгүй илүү олгосон байсан бөгөөд зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

Өмнөх аудитаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээнүүдийн санхүүжилтийг барилгын ажлын гүйцэтгэлээс илүү олгосон 4,258.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгсөн бөгөөд 2023 онд тус зөрчил давтагдан гараагүй байна.

Зорилт 2. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүдийг гэрээний хугацаанд бүрэн гүйцэтгүүлж, хүлээн аваагүй байна.

Б.1 Төсөл арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь хэрэгжүүлээгүй байна.

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад өмнөх оноос он дамжин хэрэгжих 12 төсөл арга хэмжээ тусгагдсанаас 3 төсөл арга хэмжээг 2023 онд улсын комисс хүлээн авч, 9 төсөл арга хэмжээний гүйцэтгэл дутуу үүнээс 4 төсөл арга хэмжээ нь дараа онд шилжсэн байна.

Улсын комисс хүлээн авсан 3 төсөл арга хэмжээ:

Аудитаар 2023 онд улсын комисс хүлээн авсан төсөл арга хэмжээнүүдийн бодит байдалд биет горим хэрэгжүүлэхэд дараах байдалтай байна.

✓ Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал

Сонгино суманд баригдсан 320 хүүхдийн хичээлийн байр, спорт заалны барилгын ажлыг 2021 оны 12 сарын 25-нд хүлээлгэн өгөхөөр анхны гэрээг хийсэн ч гэрээний хугацаанд ажлыг дуусгаагүй байна.

Барилга угсралтын ажлыг 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр дуусгаж улмаар барилгыг хүлээж авах 18 хүний бүрэлдэхүүнтэй улсын комисс ажиллаж, комиссын гишүүдийн олонхын саналаар барилгыг хүлээж авах боломжгүй гэж үзэж, 24 үүрэг даалгавар өгсөн байна. Барилгыг ашиглалтад хүлээн авах улсын комисс дахин ажилласан эсэхийг нягтлан үзэхэд комисс бүрэлдэхүүнээрээ дахин ажилласан дүгнэлт, хурлын тэмдэглэл байхгүй байна. Аймгийн ГХБХБГ комисс дахин ажиллаагүй, өмнө өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг ашиглагч, гүйцэтгэгч байгууллагаар гаргуулан биелэлтийг тооцож комиссын гишүүд гарын үсэг зурж баталгаажуулсан гэсэн тайлбар өгсөн.

Илрүүлэлт: Барилгыг газар дээр нь үзэхэд гадна бохир хөлдсөн, барилгын агааржуулалт муу ажилладаг агааржуулалтын хоолойн жийргэвч хийгдээгүй, комиссоос өгсөн үүргийн биелэлт бүрэн хангагдаагүй байна.



Хэдийгээр хичээлийн байр, спорт заал баригдсан нь орон нутгийн хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа хэдий ч дээрх зөрчил нь хүүхдүүд тав тухтай орчинд сурах нөхцөлийг хангахгүй байна. Тухайлбал барилга дотор ариун цэврийн өрөө байгаа ч гадаа гарч бие засах, гол тогооны агааржуулалт муугаас барилгын бүх давхарт хоолны үнэр, хэншүү тарсан нь хүүхдүүд хичээл хийхэд анхаарал төвлөрөхгүй байх нөхцөл байдлыг бий болгож байна.

Иймд гүйцэтгэгчийн төлөөлөл, комиссын гишүүд дахин ажиллаж өмнө өгсөн үүргийн биелэлтийг шалгаж шаардлагатай зарим ажлыг гүйцэтгэгчээр засварлуулах, барилгын зураг төсөв, ил далд ажлын акт, баримт материалыг ашиглагчид хүлээлгэн өгөх нь зүйтэй гэж үзлээ.

✓ Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал суудал


Тэлмэн суманд баригдсан 320 хүүхдийн хичээлийн байр, спорт заалны

60

барилгын ажлыг 2021 оны 12 сарын 25-нд хүлээлгэн өгөхөөр анхны гэрээг хийсэн бөгөөд гэрээнд өөрчлөлт оруулж ажил дуусах хугацааг 2022 оны 12 дугаар сарын 31 гэж өөрчилсөн байна. Гэтэл гэрээний өөрчлөлтийн хугацааг 10 сараар хэтрүүлж барилгын ажлыг гүйцэтгэн улсын комисст хүлээлгэн өгсөн байна.

Барилгыг ашиглалтад оруулах улсын комиссоос 18 нэр төрлийн үүрэг даалгаврыг хугацаатай өгч хэрэгжилтийг барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудсаар хянаж хангуулсан байна. Гэвч барилгын ашиглалтын явцтай газар дээр нь очиж танилцахад дараах зөрчлүүд илэрлээ.

Илрүүлэлт: Биеийн тамирын залны барилгын хучилт нимгэдсэнээс дээврийн дулаан алдагдал их цанталт үүссэн. Барилгын суурийн хаяавч тойруулан хийсэн өнгөлгөө зарим газарт ховхорч унасан, цонх хагарсан барилгын гадна бохирын цооног дүүрч



байгаатай уялдуулан усны хэрэглээг хязгаарлаж бие засах газрууд хэвийн ажиллах боломжгүй болж байгаа зэрэг зөрчлүүд байна.

Бохирын цооногийг шингээлтгүй металл ёмкосоор хийсэн нь шаардлага хангахгүй, зурагт тусгагдсан /40 мЗ-ын багтаамжтай цооног/ материал хийцээс зөрүүтэй байна.



Гадна бохир шугамын ажлыг шингээлтгүй хийснээс болж сургуулийн усны хэрэглээг хязгаарлахгүйгээр ашиглахад тухайн ёмкос ажлын 5 өдрийн хугацаанд дүүрдэг байна. Энэ нь нэг талаасаа ашиглалтын зардлыг нэмэгдүүлж, нөгөө талаасаа хүүхдүүдийн усны хэрэглээг хязгаарлах нөхцөлийг бүрдүүлж байна.

Тухайн суманд цэвэр бохир ус хариуцсан хуулийн этгээд үйл ажиллагаа явуулдаггүй тул аймгийн төвөөс бохир сорилтын зориулалттай авто тээврийн хэрэгсэл дуудлагаар ирүүлж бохирыг соруулах зайлшгүй шаардлага тулгарч байна. Тус сум нь аймгийн төсвөөс 120 км бөгөөд сард 4 удаа бохир сорилтын автомашин дуудаж, 1 удаагийн бохир соролтоор дунджаар 8 удаагийн рейс хийх тооцоолол гарч байна.


Иймд дээрх зөрчлийг засаж, гадна бохирын шугамын өөрчлөлтийг хийж, цооногийг 40 мЗ-ын шингээлттэй цооног болгон өөрчилж хийлгүүлэх нь зүйтэй гэж үзлээ

✓ Цэцэрлэгийн барилга, 150 ор

Тосонцэнгэл суманд баригдсан 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлыг 2021 оны 08 дугаар сарын 30-нд хүлээлгэн өгөхөөр анхны гэрээг хийсэн байна.

61

Барилга угсралтын ажлыг 2023 оны 11 сарын 07-нд хүлээн авч, барилгыг ашиглалтад оруулах улсын комиссоос 32 нэр төрлийн ажлыг хийх үүрэг чиглэл өгч ажилласан ч биелэлт хангалтгүй байна гэж үзлээ.



Илрүүлэлт: Гадна дээврийн ус зайлуулах хоолойг ф150-ын хоолой болгож өргөсгөөгүйгээс ус хальж хөлдсөн, барилгын суурийн эргэн тойрон хийсэн хавтан өнгөлгөө зарим газарт ховхорч унасан, гадна хаалганы саравч хийгээгүй, гадна цэвэр усан хангамжийн худгаас ирж байгаа хэсэгт хөлдөлт үүссэн, урлагийн танхимын үзэгчдийн хэсэгт нэг гэрэлтүүлэг дутуу,



шалны хулдаасыг наах зэрэг ажлууд хийгдээгүй, техникийн иж бүрэн баримт бичгийг ашиглагчид хүлээлгэж өгөөгүй байна.

Дээрх илэрсэн барилгын зөрчлүүдийг барилгын гүйцэтгэгч компаниар арилгуулах арга хэмжээ авч, барилгын техникийн иж бүрэн баримт бичгийг ашиглагчид хүлээлгэн өгөх нь зүйтэй гэж үзлээ.

Төлөвлөсөн хугацаанд хэрэгжээгүй 9 төсөл арга хэмжээ:

Тайлант онд хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдээс дараах төсөл арга хэмжээнүүд гэрээний хугацаанд ашиглалтад ороогүй, төсөл арга хэмжээний гэрээг сунгаагүй, зарим төсөл арга хэмжээний гэрээг үндэслэлгүй сунгасан байна.

✓ Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал

Идэр сумын сургуулийн барилгын ажлыг 2021 оны 12 сарын 25-нд хүлээлгэн өгөхөөр анхны гэрээг хийсэн бөгөөд гэрээнд өөрчлөлт оруулж ажил дуусах хугацааг сунгаж 2022 оны 12 дугаар сарын 31 гэж өөрчилсөн ч уг хугацаанд барилгын ажлыг дуусгаагүй бөгөөд дахин сунгалт хийсэн байна.



Аудитаар барилгын ажлын гүйцэтгэлд биет горим хэрэгжүүлэн ажиллахад барилгын гүйцэтгэл 90 орчим хувьтай, биеийн тамирын заал, урлагийн заалны дотор засал, зарим хэсгийн хаалга суулгах ажлууд хийгдээгүй байна.

Төсөл арга хэмжээг гэрээний хугацаанд ашиглалтад оруулах боломжтой байсан гэж үзлээ. Учир нь тус барилгын санхүүжилтийг барилгын гүйцэтгэлд үндэслэн олгоогүй, 2022 онд санхүүжилтийг илүү олгосон, 2023 онд материалын үнийн зөрүүний 55 хувийг олгосон байна.

Тус төсөл арга хэмжээг ашиглалтад оруулаагүй нь ажиллах хүчний зардлын зөрүүг төсөвт тусгуулж, авсны дараа хүлээлгэн өгөх зорилгыг агуулсан байна.

✓ Жавхлант цогцолбор сургуулийн 2 дугаар байрны барилга

Улиастай сумын нутаг дэвсгэрт байрлах сургуулийн барилгын ажлыг 2021 оны 12 сарын 25-нд хүлээлгэн өгөхөөр анхны гэрээг хийсэн бөгөөд гэрээнд өөрчлөлт оруулж ажил дуусах хугацааг сунгаж 2022 оны 12 дугаар сарын 31 гэж өөрчилсөн ч барилга угсралтын ажлыг дуусгаагүй байна.

Улиастай сумын Жавхлант цогцолбор сургуулийн 640 хүүхдийн хичээлийн байр, биеийн тамирын заалны барилгын ажлыг улсын комиссын 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 44/2021 тоот дүгнэлтээр 640 хүүхдийн хичээлийн байрны барилгыг хэсэгчлэн хүлээн авсан байна. Ингэхдээ үүрэг даалгаврын жагсаалт гаргаагүй, улсын комисс дахин ажиллахаар шийдвэрлэсэн байна.

Харин ашиглагч байгууллагаас хичээлийн шинэ байрны барилгын ашиглалтын явцад гарч байгаа эвдрэл, гэмтлийн жагсаалтыг гаргах, тус жагсаалтын дагуу гүйцэтгэгч компанийн хийж гүйцэтгэсэн ажилд хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан байна.

Уг комиссын хурлын тэмдэглэлд сургуулийн захиргаанаас эвдрэл гэмтлийн жагсаалт гарган өгөх, “Бэр сүм” ХХК-ний зүгээс дотор бохир, ариун цэврийн өрөөний асуудлыг шийдвэрлэж, бусад эвдрэл гэмтлийн асуудлыг спорт заалны барилгын ажил хийгдэх явцад бүр мөсөн дуусгаж, спорт заалны дутуу ажлыг 2023 оны 06 дугаар сарын 15-ны дотор хийж гүйцэтгэхээр тохиролцсон байна.

Харин газар дээр нь очиж үзэхэд спорт заалны барилгын шал, туслах өрөөнүүдийн шал, хувцас солих болон багш нарын өрөөний тохижилт хийгдээгүй байна.



Тухайн төсөл арга хэмжээтэй холбоотой санхүүжилтийг 100 олгосон байхад хэрэгжилтийг хангуулаагүй байна. Энэхүү барилгын ажил гэрээний хугацаанд хэрэгжээгүй нь гүйцэтгэгчээс шалтгаалсан байна гэж үзлээ.

Тухайн барилгын ажлыг 2023 оны хичээлийн жил дуусахаас өмнө хүлээн авах арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна. Учир нь тус сургуулийн хуучин заалны барилгад нуралт үүссэн, сургалт явуулах боломжгүй нөхцөл байдалтай, хүүхдэд аюултай орчин бүрдсэн байна.

Гэрээний хугацаанд хэрэгжээгүй шалтгаан нь анхны ажлын зурагт тусгагдсан спорт заалны резин шалыг модон шалаар солих шаардлагыг зургийн байгууллагын зүгээс тавьснаас үнийн зөрүү үүссэн, ажиллах хүчний зардлыг шинэчилсэн тарифт цалингаар тооцуулж төсөвт магадлал хийлгүүлж, санхүүжилт олгогдсоны дараа ажлыг хүлээлгэн өгөх гэсэн тайлбар өглөө.

✓ Дотуур байрны барилга, 100 ор

Цэцэн-Уул суманд баригдаж буй 100 ортой дотуур байрны барилгын ажлыг 2023 оны 08 сарын 31-ны өдөр хүлээлгэн өгөхөөр анхны гэрээг хийсэн ч гэрээний хугацааг хэтрүүлсэн, гэрээний хугацааг барьцаа хөрөнгийн дансанд хөрөнгө төвлөрүүлсэн гэсэн үндэслэлээр сунгасан байдалтай байна.

Тус барилгатай холбоотой санхүүжилтийг улсын төсвөөс 100 хувь олгосон бөгөөд гүйцэтгэгчид санхүүжилтийн 89.1 хувийг олгож, 10.9 хувийг аймгийн төрийн сангийн барилгын барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 78.2 хувьтай байна.



Төсөл арга хэмжээ гэрээний хугацаанд хэрэгжээгүй нь хүйтний улиралд барилгын ажлыг гүйцэтгэхэд хүндрэл учирсан тул гэрээний хугацааг сунгаж, барилга угсралтын ажилд технологийн зогсолт хийх шаардлага тулгарсан гэсэн тайлбарыг ирүүлсэн. Энэ нь нэг талаасаа захиалагч болон хяналт хэрэгжүүлэгч байгууллагууд дулааны улиралд ажлыг нь эхлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй, нөгөө талаас гүйцэтгэгчийн хүний нөөц хангалтгүй байдал, ачаа тээвэрлэлтийн хугацаа зэрэг нөлөөлсөн гэжээ.

✓ Дотуур байрны барилга, 75 ор

Асгат суманд баригдаж буй 75 ортой дотуур байрны барилгын ажлыг 2021 оны 11 сарын 01-ны өдөр хүлээлгэн өгөхөөр анхны гэрээг хийсэн ч хэтрүүлсэн, цаашид тухайн барилга ашиглалтад орох эсэх нь тодорхойгүй байдалтай байна.

Аудитаар барилгын ажил гүйцэтгэлтэй танилцахад гадна өнгөлгөөний тоосгон өрлөг, хамар хана, шал, хаалга цонх, дотор цэвэр бохир ус, холбоо, дохиолол, цахилгаан, гадна бохир, цооног, гадна тохижилтын ажлууд хийгдээгүй байна.



Уг төсөл арга хэмжээний гэрээний санхүүжилтийг 100 хувь, материалын үнийн өсөлтийн нэмэгдлийн санхүүжилтийн 95 хувийг олгосон байхад барилгын гүйцэтгэл 60 орчим хувьтай байна.

Гэрээний хугацаанд хэрэгжээгүй талаар гүйцэтгэгч байгууллагаас тодруулга авахад:

- ✓ Анх улсын төсөвт тусгахдаа зураг төсөвт үндэслээгүй, баримжаагаар 1,000.0 төгрөг баталсан

- ✓ Төсөв батлагдсаны дараа зураг төсөв хийгдсэн бөгөөд батлагдсан төсөвт тохируулан төсвийг хийсэн
- ✓ Зургаасаа төсөв нь зөрүүтэй, барилгын сууриас гарсан цэвдэгтэй хөрсийг солих, зайлуулах ажлыг ажлын зурагт заасан байгаа боловч магадлагдсан төсөвт огт тусгаагүй хаягдсан, барилгын арматур дутуу тооцогдсон гэх мэт
- ✓ Магадлалаар батлагдсан ажлын зурагт тусгагдсан зарим ажлууд болон материалын тооцооллыг төсөвт дутуу тусгасан, тусгалгүй орхигдуулсан
- ✓ 2022 онд үнийн өсөлтийн зөрүү тооцохдоо төсөвт тусгагдаагүй материалыг оруулан тооцоогүй
- ✓ Ажиллах хүчний зардлыг хүчингүй болсон тарифт цалингийн жишгээр тооцсон зэрэг нь санхүүжилт дутагдах нөхцөлийг бүрдүүлж байна, иймд барилгын зураг төсвийг магадлалаар дахин оруулах шаардлагатай гэсэн тайлбар ирүүлсэн.

Асгат сумын ерөнхий боловсролын сургуульд 268 хүүхэд суралцдаг бөгөөд үүнээс 65 орчим хүүхэд дотуур байранд амьдардаг байна.

Аудитаар дотуур байрны нөхцөл байдалтай танилцахад сургуулийн нэг жигүүрийг дотуур байрны зориулалтаар ашиглаж байна. Энэ нь хүүхдүүд 2 ээлжээр хичээллэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Улсын төсвийн 2024 оны төсөвт тус барилгатай холбоотой санхүүжилт батлагдаагүй байгаа нь тухайн барилгын ажил цаашид удаашрах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Энэхүү барилга угсралтын ажлын зураг төсөвт дахин магадал хийлгэж, нэмэлт хөрөнгө шаардлагатай эсэхийг мэргэжлийн байгууллагаар тодорхойлуулж, барилгыг нэн даруй ашиглалтад оруулах арга хэмжээг авч ажиллах шаардлагатай гэж үзлээ.

✓ Засаг даргын тамгын газрын барилга

Шилүүстэй суманд баригдаж буй Засаг даргын Тамгын газрын барилгын ажлыг 2021 оны 08 сарын 20-ны өдөр хүлээлгэн өгөхөөр анхны гэрээг хийсэн ч гэрээний хугацаанд барилга угсралтын ажил хийгдээгүй байна.

Аудитаар барилгын гүйцэтгэлтэй танилцахад зураг төсөвт тусгагдсан тогооны барилгын оронд гадна ханыг тоосгоор өнгөлсөн, дээврийн ажил, гадна зам талбай, зүлэгжүүлэлтийн ажлаас бусад нь хийгдсэн, барилгын ажлын гүйцэтгэл 90 орчим хувьтай байна.



Барилгын ажлын санхүүжилтийн 98.4 хувийг гүйцэтгэгчид олгосон байхад барилга угсралтын ажил бүрэн дуусаагүй, барьцаа хөрөнгийн дансанд хөрөнгө төвлөрүүлсэн үндэслэлээр гэрээг сунгасан байна.

Барилга угсралтын ажил гэрээний хугацаанд хэрэгжээгүй нь 2023 онд батлагдсан санхүүжилт удааширч олгогдсон, гүйцэтгэгчид удаа дараа шаардлага хүргүүлж ажилласан боловч графикийн дагуу болон гэрээний хугацааг бариагүйтэй холбоотой гэсэн тайлбар ирүүлсэн.

Дараа онд дамжин хэрэгжих төсөл арга хэмжээ:

2023 онд батлагдсан төсөл арга хэмжээнүүдээс дараах 4 төсөл арга хэмжээ он дамжин 2024 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан байна.

- ✓ Хөгжимт жүжгийн театрын барилга, 800 суудал /Улиастай сум/
- ✓ Соёлын төвийн барилга, 200 суудал /Нөмрөг сум/
- ✓ Соёлын төвийн барилга, 200 судал /Түдэвтэй сум/
- ✓ Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 3км /Их-Уул сум/

Аудитаар эдгээр барилгын ажлын явцтай танилцахад дараах байдалтай байна.

- ✓ Хөгжимт жүжгийн театрын барилга, 800 суудал /Улиастай сум/

Барилгыг газар дээр нь үзэхэд барилгын дотор засал, гэрэлтүүлэг, шал, хаалга суулгах, тайзны ажил, үзэгчдийн суудал зэрэг үндсэн ажлууд дутуу байна. Улсын төсвийн 2024 оны төсөвт 5,881.9 сая төгрөг батлагдсан байна.



- ✓ Соёлын төвийн барилга, 200 суудал /Нөмрөг сум/



Барилгын газар, суурийн ажил, хана хамар, ханын ажил, хучилт, дээврийн ажил, шат довжоо, хаалга, цонх, гадна, дотор заслын зарим ажлуудыг хийж гүйцэтгэсэн, барилга угсралтын ажил 80 орчим хувьтай байна. Улсын төсвийн 2024 оны төсөвт 705.6 сая төгрөг батлагдсан байна.

Ашиглагчийн төлөөлөлтэй газар дээр нь уулзаж ярилцахад барилга дотор номын сангийн зориулалттай өрөө тасалгаа байхгүй. Зөвхөн Соёлын төвийн барилга нь баригдахаар төлөвлөгдсөн. Зураг төсөвт гадна тохижилт ер тусгагдаагүй гэж танилцуулсан. Аймгийн ГХБХБГ дээр байгаа бичиг баримттай танилцахад Соёлын төвийн гадна тохижилт, ханын өөрчлөлт, тайзны технологи тоног төхөөрөмжийн төсөв хийгдсэн бөгөөд төсөвт тусгагдаагүй байна.

Номын сангийн зориулалтын өрөө тасалгааг барилга дотор багтааж хийх боломжийг судалж, технологийн тоног төхөөрөмж, тайзны хөшиг, үзэгчдийн сандал зэргийг Соёлын яаманд тавьж шийдвэрлүүлэх нь зүйтэй.

- ✓ Соёлын төвийн барилга, 200 судал /Түдэвтэй сум/

Барилга угсралтын ажлын барилгын үндсэн хийц суурь, өрлөг, хучилт дээвэр, цонх угсралтын ажлууд хийгдсэн. Барилгын ажлын гүйцэтгэл 70 орчим хувьтай, улсын төсвийн 2024 оны төсөвт 548.0 сая төгрөг батлагдсан байна.



✓ Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 3км /Их-Уул сум/



Үндсэн сумын доторх 3 км хатуу хучилттай авто замын ажил хийгдсэн, 2 талаар явсан явган зам, явган замын хашлага, замын тэмдэг тэмдэглэгээ хийгдээгүй байна. Энэ барилгын материалын үнэ өссөнтэй холбоотой төсөв хүрэлцэхгүй байгаа тул төсөв нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн хүсэлтийг гүйцэтгэгчээс ирүүлсэн байна. Уг хүсэлтээ автозамын хөгжлийн төвд хүргүүлсэн хэдий ч одоог хүртэл шийдвэрлэгдээгүй байна. 2024 оны төсөвт 254.5 сая төгрөг тусгагдсан нь өмнөх гүйцэтгэлийн үлдэгдэл төсөв байна.

Иймд гүйцэтгэгч байгууллагаас ирүүлсэн төсвийг магадлалаар баталгаажуулан нэмэлт хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Үндсэн зам хажуугаасаа сэтэрч, хагарах эрсдэл тулгарсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнүүдийн гэрээний хугацаа, гэрээний сунгалт зэрэгт шинжилгээ хийхэд төсөл арга хэмжээг анх төлөвлөсөн хугацаанд нь гүйцэтгэсэн тохиолдол байхгүй, гэрээний хугацааг хэтрүүлсэн байна.

Мөн гэрээний хугацаанд хэрэгжээгүй зарим төсөл арга хэмжээний гэрээний хугацааг сунгаагүй байна.

Төсөл арга хэмжээг гэрээний хугацаанд гүйцэтгүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй, захиалагч гүйцэтгэгчийн хооронд гэрээний хариуцлага болон үүргийн биелэлт хангалтгүй, гэрээний үүргийн биелэлтээ хангаагүй хуулийн этгээдэд хариуцлага тооцож, арга хэмжээ авч ажилладаггүй байна.

Ийнхүү гэрээний хугацаанд төсөл арга хэмжээг хэрэгжүүлээгүй байдал нь тухайн төсөл арга хэмжээний өртөг нэмэгдэх, он дамжин удаашрах, хөрөнгө оруулалтын санхүүжилтийг зориулалт бус, эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөлийг бий болгож байна гэж үзлээ.

Нөгөө талаасаа засгийн газраас гаргаж буй шийдвэрүүдтэй холбоотой байна. Тухайлбал төсөв батлахдаа санхүүжилтийг хэт бага дүнгээр баталж он дамжуулдаг, материалын үнийн зөрүү, ажиллах хүчний зардлын үнэ тарифтай холбоотой шийдвэрүүд, ТЭЗҮ, зураг төсөвгүй төсөл арга хэмжээг төсөвт тусган баталсан зэрэг байна. Эдгээр нь гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгэсэн хуулийн этгээдэд санхүүжилт олгогдохгүй байх магадлал байдаг тул дээрх зөрүү,

67

өөрчлөлтийн санхүүжилтээ авахын тулд барилгын ажлыг гэрээний хугацаанд гүйцэтгэхгүй, хугацааг санаатай хойшлуулдаг, төсөв хүрэлцэхгүй нэрийдлээр анхны төсөвт дахин магадлал хийлгэж нэмэлт төсөв батлуулдаг байдал ажиглагдлаа.

Иймд хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээг анх төлөвлөсөн хугацаанд нь хэрэгжүүлж дуусгадаг, засгийн газраас гаргасан шийдвэрийн дагуу олгож буй нэмэлт санхүүжилтийг олгохдоо гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгэсэн байдлыг харгалзан үздэг байх, гүйцэтгэгч нарыг нэг газарт 3 жил эсвэл 3 удаагийн төсөл арга хэмжээ хэрэгжүүлдэг тогтолцоонд шилжүүлэх нь зүйтэй байна.

Ингэснээр ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, бие биедээ шударга хяналт тавих нөхцөл бүрдэнэ гэж үзлээ.

Б.2 Барилгын ажлын гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналт хангалтгүй, улсын комиссоос өгсөн үүрэг даалгавар хэрэгжээгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт эрх шилжин хэрэгжиж буй төсөл арга хэмжээний явцад хяналтыг аймгийн ГХБХБГ, аймгийн ЗДТГ-ын дэргэдэх ХБТХО-ын хэлтсийн холбогдох мэргэжилтнүүд хэрэгжүүлж байна.

Өмнөх оноос дамжин хэрэгжиж буй барилгын ажлын гүйцэтгэл дутуу 12 төсөл, арга хэмжээнээс 7 төсөл арга хэмжээний явцад ГХБХБГ 16 удаагийн, аймгийн ХБТХОХ 4 удаагийн хяналтыг хэрэгжүүлжээ.

Хүснэгт 4. Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний ажилд хэрэгжүүлсэн хяналтын мэдээлэл /тоо/

Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч байгууллагын нэр	Хяналт хийсэн тоо	Өгсөн үүрэг даалгавар	Биелэлт тооцсон эсэх
Дотуур байрны барилга, 100 ор /Завхан, Цэцэн-Уул сум/	Төгс хурц консалтинг ХХК	5	38	Үгүй
Дотуур байрны барилга, 75 ор /Завхан, Асгат сум/	Эко энерги ресурс ХХК	1	4	Үгүй
Соёлын төвийн барилга, 200 суудал /Завхан, Нөмрөг сум/	Ар Си Ди интернэшнл ХХК	2	4	Үгүй
Соёлын төвийн барилга, 200 суудал /Завхан, Түдэвтэй сум/	Этүгэн жим ХХК	1	8	Үгүй
Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Завхан, Идэр сум/	Хан жаргалант стоунс ХХК	1	1	Үгүй

Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Завхан, Тэлмэн сум/	Тэнгэрийн тэмдэг ХХК	5	35	Үгүй
Цэцэрлэгийн барилга /Завхан, Тосонцэнгэл сум/	Пирамид проект ХХК	5	49	Үгүй
		20	139	

Аудитын явцад хяналтыг хэрэгжүүлж байгаа байгууллагуудын хяналт хийсэн тайланг шалгахад Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар нь хяналтын ажлын график гарган хяналтыг хэрэгжүүлж 139 үүрэг даалгавар өгч ажилласан ч биелэлтийг тооцоогүй байна.

Харин ХБТХО-ын хэлтэс 4 удаагийн үе шатны ажлуудад хяналт хийсэн гэх боловч энэ нь баримтаар нотлогдохгүй байна.

Хүлээн авсан төсөл арга хэмжээний хүрээнд улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг газар дээр нь нүд үзэж шалгадаггүй, биелэлтийг бүрэн хангаагүй байхад захиалагч болон хяналт хэрэгжүүлэгч байгууллагууд гарын үсгээр баталгаажуулан хүлээн авсан байна. Тухайлбал:

- ✓ Хэрэгжсэн үүрэг даалгаврын биелэлтийг хяналтын тайлангаар баталгаажуулаагүй
- ✓ Асгат сумын 75 хүүхдийн дотуур байр, Нөмрөг, Түдэвтэй сумдын соёлын төвийн барилга, Идэр сумын 320 хүүхдийн сургуулийн байранд өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангалтгүй, өгсөн үүрэг даалгавраа эргэж хянаагүй
- ✓ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд ашиглалтад хүлээн авсан Тэлмэн, Сонгино сумдын 320 хүүхдийн сургууль, Тосонцэнгэл сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн ажлыг хүлээж авах ажлын хэсэг нийт 74 үүрэг даалгаврын биелэлт өгсөн боловч одоог хүртэл үүрэг даалгаврын биелэлтийн гүйцэтгэл хангалтгүй зэрэг байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжиж, улсын комисс хүлээн авсан төсөл арга хэмжээний үүргийн биелэлтийг аудитын тайлангийн Б.2 хэсэгт, төсөл арга хэмжээ бүрээр тусгасан.

Харин 2021, 2022 онд улсын комисс хүлээн авч үүрэг даалгавар өгсөн болон өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг шалган үзэхэд дараах байдалтай байна.

- ✓ Цэцэн-уул сумын хүүхдийн цэцэрлэг 2021 онд ашиглалтад орсон байхад үүрэг даалгаврын биелэлт одоог хүртэл хэрэгжээгүй, бүтэн 2 жил болсон байна.
- ✓ Өмнөх аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид Улиастай суманд хэрэгжсэн гудамж төслийн хүрээнд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг хүлээн

69

авах комиссын үүргийн биелэлтийг хэрэгжүүлээгүй зөрчилд албан шаардлага өгсөн бөгөөд биелэлт хангагдаагүй байна.

Ийнхүү үүрэг даалгаврын биелэлтийг бодитоор хянахгүй, захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байгаа нь гүйцэтгэгч нар төсөл арга хэмжээг хугацаанд нь хэрэгжүүлэхгүй, ашиглагч байгууллагын шаардлагыг бүрэн биелүүлэхгүй байх нөхцөлүүдийг бүрдүүлж байна.

ГХБХБГ-т барилгын чиглэлээр 5 албан хаагч хяналтыг хэрэгжүүлдэг ч эрчим хүч, авто замын чиглэлийн мэргэжилтэн дутмаг байна.

Иймээс холбогдох мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, дутмаг байгаа мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх шаардлагатай байна.

Аймгийн төрийн сангийн данс дахь техник хяналтын зардлаас 2023 онд 412.9 сая төгрөгийг улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалт, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний явцын хяналтыг хэрэгжүүлэхэд зориулан зарцуулжээ. Үүнээс 110.2 сая төгрөгийг аймгийн ГХБХБГ-ын нэмэлт дансаар дамжуулан зарцуулсан байна.

Техник хяналтын зардлын зарцуулалтыг анхан шатны баримттай тулган шалгахад дараах зөрчлүүд илэрлээ.

Аймгийн Засаг дарга:

- ✓ Аймгийн ЗДТГ-ын автомашинуудын сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээнд 23.5 сая төгрөг,
- ✓ Тамгын газрын албан хэрэгцээнд нийт 3.8 сая төгрөг
- ✓ Нормын хувцас өмсөх эрх бүхий биш албан тушаалтнуудад ажлын хувцас худалдан авахад 15.8 сая төгрөг,
- ✓ Отор нүүдэл эргэх ажлын шатахууны зардалд 5.0 сая,
- ✓ Анхан шатны баримтгүй зарцуулсан 3.0 сая төгрөгийн шатахуун зардал зэрэг нийт 51.0 сая төгрөгийг зориулалт бус, үр ашиггүй зарцуулжээ.

Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар:

- ✓ Тэмцээн уралдаанд оролцсон албан хаагчдад 4.2 сая төгрөгийн томилолт олгосон
- ✓ Байгууллагад 19.0 сая төгрөгийн техник хэрэгсэл худалдан авсан
- ✓ Байгууллагын гадна тохижилт хайс хамгаалалтад 23.5 сая төгрөг, нийт 46.7 сая төгрөгийг зориулалт бус, үр ашиггүй зарцуулжээ.

Техник хяналтын зардлыг үр ашиггүй, анхан шатны баримтгүй шатахууны зардалд зарцуулсан, тэмцээн уралдаанд оролцсон алба хаагчдад томилолт олгосон, худалдан авсан сэлбэг хэрэгсэл биетээр ирээгүй зэрэгтэй холбоотой 15.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, зардлыг зориулалт бусаар зарцуулсан 81.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

20

Захиалагчийн хяналтын зардлыг хуваарилахдаа тухайн жилийн хяналтаар ажиллах төлөвлөгөөнд үндэслэн олгоогүйгээс барилга байгууламжийн үе шат бүрд хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлдэггүй, зардлыг зориулалт бусаар зарцуулах эрсдэл бий болсон байна.

Мөн техник хяналтын зардлыг зориулалт бус зарцуулж байгаа нь барилгын хяналт бүрэн хэрэгжихгүй байхад нөлөөлж байна гэж үзлээ.

Иймд техник хяналтын зардлыг олгохдоо хяналт хийсэн тайлан, холбогдох баримт материалд үндэслэн олгож, зориулалтын дагуу зарцуулж байх шаардлагатай байна.

Б.3 Улсын комисс хүлээн авсан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаагүй байна.

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдаж, эрх шилжсэн 18 төсөл арга хэмжээнээс улсын комисс хүлээн авсан 9 төсөл арга хэмжээг данс бүртгэлд тусгасан байдлыг төсөвт өртөгтэй тулган шалгахад:

- ✓ Барилга угсралтын ажлуудыг ТӨБЗГ-ын шийдвэрт үндэслэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаж байна. Гэвч тухайн шийдвэр нь барилгын төсөвт өртгөөс зөрүүтэйгээс данс бүртгэлд зөрүүтэй тусгасан. Энэ нь төсөл арга хэмжээг хүлээн авснаас хойш нэмэлт санхүүжилт олгож байгаатай холбоотой байна.
- ✓ Сумын төвийн шинэчлэл, гудамж төсөл, авто зам гэх мэт нийтийн эзэмшлийн зориулалттай төсөл арга хэмжээнүүдийг данс бүртгэлд тусгаагүй байна.

Хүснэгт 5. Улсын комисс хүлээн авсан төсөл арга хэмжээг данс бүртгэлд тусгасан мэдээлэл /сая.төг/

д/д	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Данс бүртгэлд тусгасан өртөг	Зөрүү	Хөрөнгө бүртгэх шийдвэр
1	Сургуулийн барилга, спорт заал 320 суудал /Сонгино сум/	5,075.7	5,075.7	0.00	ТӨБЗГ-ын 2023.12.26-ны 798 дугаар тогтоол
2	Сургуулийн барилга, спорт заал 320 суудал /Тэлмэн сум/	4,604.7	4,604.7	0.00	ТӨБЗГ-ын 2023.12.26-ны 798 дугаар тогтоол
3	Цэцэрлэгийн барилга /Тосонцэнгэл сум/	1,867.6	1,867.6	0.00	ТӨБЗГ-ын 2023.12.26-ны 798 дугаар тогтоол
4	Цэцэрлэгийн барилга /Цэцэн-Уул сум/	1,859.8	1,641.4	218.40	Цэцэн-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн тушаал
5	Засаг даргын тамгын газрын барилга /Түдэвтэй сум/	1,469.2	1,395.0	74.20	Гэрээний үндэслэсэн дүнд
6	Засаг даргын тамгын газрын барилга /Ургамал сум/	1,460.8	1,398.1	62.70	Гэрээний үндэслэсэн дүнд
7	Гудамж төсөл /Улиастай сум/	9,882.8	0.0	9,882.80	

8	Сумын төвийн /Алдархаан сум/	шинэчлэл	4,949.90	0.00	4,949.90
9	Нисэх буудлын авто замын уулзвараас сумын төв хүртэл авто зам, 6.7 км сумын төвийн хатуу хучилттай авто зам /Алдархаан сум/		5,388.30	0.00	5,388.30

Жишээ нь хүснэгтэд тусгагдсан Тосонцэнгэл сумын цэцэрлэгийн барилгын төсөвт өртөг 2024 онд 2,685.6 сая төгрөг болж, 818.0 сая төгрөгийн үнийн өсөлт гарч, данс бүртгэлд тусгасан дүнгээс зөрөхөөр байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээг данс бүртгэлд тусгах талаар өмнөх оны аудитаар албан шаардлага хүргүүлсэн ч нийтийн эзэмшлийн зориулалттай хөрөнгө оруулалтыг данс бүртгэлд тусгаагүй байна. Зөвлөмжийн хэрэгжилт хангагдахгүй байгаа нь аймгийн Орон нутгийн өмчийн газар улсын төсвийн хөрөнгө оруулалтын хүрээнд хэдэн төгрөгийн төсөвт өртөгтэй, ямар ажил хийгдсэн талаарх мэдээлэл дутмаг байгаатай холбоотой байна гэж үзлээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээг тухай бүр данс бүртгэлд тусгаж эзэмшүүлэхгүй байх нь хөрөнгө эзэнгүйдэх, үрэгдэх, хувийн эзэмшилд шилжих эрсдэлийг бий болгож байна.

Нэгэнт орон нутагт хэрэгжсэн төсөл арга хэмжээний ашиглалт, хамгаалалтад аймгийн Орон нутгийн өмчийн газар хяналт тавих үүрэг хүлээдэг тул улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг хүлээн авах улсын комисст орон нутгийн өмчийн төлөөллийг заавал оролцуулдаг байх нь зүйтэй гэж үзлээ.

Зорилт 3. Улсын комисс хүлээн авч ашиглалтад орсон төсөл арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрч, орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байна.

Ашиглалтад хүлээн авч, данс бүртгэлд тусгасан төсөл арга хэмжээнүүдийг зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна. Тухайлбал:

- Тэлмэн сумын ерөнхий боловсролын сургуульд 530 хүүхэд суралцаж байгаа бөгөөд хуучин барилгын зарим хэсэгт сургалтын үйл ажиллагааг явуулж, нэг ээлжээр хичээллэх боломжтой болсон

- Сонгино сумын ерөнхий боловсролын сургуульд 316 орчим хүүхэд суралцаж байгаа нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан 320 хүүхдийн хичээлийн байрыг зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар ашиглаж, сургалтын үйл ажиллагааг нэг ээлжээр хичээллүүлж байна.

Энэ нь хүүхдүүд өөрсдийгөө хөгжүүлэх, чөлөөт цагаараа өөрийн сонирхсон дамжаа, спортын төрөл бүрийн секц, дугуйлан зэрэгт хамрагдах боломжийг олгож байна.

- Тосонцэнгэл сумын 3 дугаар цэцэрлэгт 107 хүүхэд суралцаж байгаа

72

бөгөөд өмнөх онуудад гэр цэцэрлэгтэй байсан тул хүүхдийн тоо харьцангуй бага байсан, шинэ цэцэрлэг ашиглалтад орсноор тойргийн хүүхдүүд бүрэн хамрагдах нөхцөл бүрдсэн, 2024 оны хичээлийн жилээс 150 хүүхэд хамруулж, бүрэн хүчин чадлаараа ажиллах боломжтой болсон зэрэг хэрэгцээ шаардлагад нийцсэн байна.

Улсын комисс хүлээн авсан төсөл, арга хэмжээнүүд нь орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байна гэж үзлээ.

Аудитаар нийт 25,507.5 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 25.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3,673.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 21,838.5 сая төгрөгийн зөрчилд 7 заалт бүхий зөвлөмж хүргүүлээ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан төсөл арга хэмжээнүүдэд зураг төсвийн магадлал хийгдсэн байна.
2. Өмнөх оноос он дамжин хэрэгжсэн төсөл арга хэмжээг хөрөнгө оруулалтын жагсаалтад бүрэн тусгаагүй байна.
3. Батлагдсан төсөл арга хэмжээг гэрээний хугацаанд дуусгадаггүй, анхны төсөвт дахин магадлал хийлгүүлж, төсөв нэмэгдүүлэх байдал их байна.
4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний санхүүжилтийг 2022 оны барилгын ажлын гүйцэтгэлээс илүү олгосон байхад гэрээний хугацаанд бүрэн дуусаагүй бөгөөд гүйцэтгэгч нь гэрээний үүргийн биелэлтийг хангаагүйгээс шалтгаалсан байна.
5. Төсөл арга хэмжээг гэрээний хугацаанд хэрэгжүүлэх, гэрээний үүргийн биелэлтийг хангуулах талаар захиалагчийн хяналт хангалтгүй, гэрээний үүргийн биелэлтийг дүгнэж хуулийн этгээдэд хариуцлага тооцоогүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаагүй байна.
6. Улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг захиалагч биеэр үзэж, хяналт хэрэгжүүлээгүй байна.
7. Техник хяналтын зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.
8. Хэрэгжсэн төсөл арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд үнийн зөрүүтэй тусгасан байна.
9. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бүрэн хэрэгжсэн төсөл арга хэмжээ нь орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байна.
10. Улсын комисс хүлээн авсан барилгын зураг, төсөв, ил далд ажлын акт, гүйцэтгэлийн зураг, холбогдох бичиг баримтыг ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөөгүй байна.
11. Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын хүрээнд хэдэн төгрөгийн төсөвт өртөгтэй, ямар ажил хийгдсэн талаарх мэдээлэлгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад:

1. Гэрээний хугацаанд өөрчлөлт оруулах онцгой нөхцөл үүсээгүй тохиолдолд гэрээний хугацааг сунгахгүй байх, гэрээний үүргийн биелэлтийг хангуулан ажиллах;
2. Асгат сумын хүүхдийн дотуур байрны барилга угсралтын ажлын зураг төсөвт дахин магадал хийлгэж, нэмэлт хөрөнгө шаардлагатай эсэхийг мэргэжлийн байгууллагаар тодорхойлуулж, барилгыг нэн даруй ашиглалтад оруулах арга хэмжээг авах;
3. Идэр сумын сургууль, спорт заалны барилга, Шилүүстэй сумын ЗДТГ-ын барилга, Цэцэн-Уул сумын дотуур байрын барилга, Жавхлант цогцолбор сургуулийн 2 дугаар байрны барилгын ажлуудыг 2024 онд багтаан бүрэн ашиглалтад оруулах;
4. Данс бүртгэлд зөрүүтэй тусгасан барилга байгууламжийн өртгийг капиталжуулж өртгийн зөрүүг арилгах арга хэмжээ авах;
5. Данс бүртгэлд тусгаагүй нийтийн эзэмшлийн зориулалттай хөрөнгийг эзэмшүүлж, ашиглалт хамгаалалтад хяналт тавьж ажиллах;
6. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээг хүлээн авах улсын комиссын бүрэлдэхүүнд аймгийн Орон нутгийн өмчийн газрын төлөөллийг оролцуулж байх;
7. Улсын комисс хүлээн авсан төсөл арга хэмжээний барилгын зураг, ил далд ажлын акт, гүйцэтгэлийн зураг болон бусад холбогдох бичиг баримтыг ашиглагч байгууллагад бүрэн хүлээлгэж өгөх;
8. Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 11 дугаар сарын 25-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

74

Үндэсний аудитын газрын нэгтгэсэн аудитын тайланд тусгуулах санал

1. Захиалагч болон гүйцэтгэгчийн хооронд үүсэх ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх эрх зүйн орчныг сайжруулах шаардлага байна;
2. Анхны гэрээний хугацаанд хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх, хугацаандаа хэрэгжээгүй тохиолдолд гэрээг сунгах шалгуур, эрх зүйн орчныг тодорхой болгох;
3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 оноос өмнө зураг, төсөв нь хийгдсэн зарим төсөл арга хэмжээнүүдийн ажиллах хүчний зардал хуучин тарифт өртгөөр хийгдсэн байгаагаас зөрүү санхүүжилтийг улсын төсөвт тусгуулж авахын тулд гүйцэтгэгч хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг гэрээний хугацаанд ашиглалт оруулдаггүй байдал ажиглагдлаа. Иймд 2021 оноос өмнөх онуудад зураг төсөв нь батлагдсан төсөл арга хэмжээнүүдийн ажиллах хүчний зардлын зөрүүг нэгдсэн журмаар тооцон олгох талаар холбогдох яамдад уламжлан, олон жил үргэлжлэн ашиглалтад ороогүй байгаа барилгын ажлыг дуусгах арга хэмжээ авах.

8

Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал:



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд Завхан аймагт хийгдсэн Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн аудитын тайланд өгөх саналаа хавсралтаар хүргүүлээ.

Хавсралт 2 хуудастай.

ОРЛОГЧ



Ц.УЛАМ-ОРГИХ

Doc toot a5

8123067162

**УЛСЫН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН СЭДЭВТ ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН
ТАЙЛАНГИЙН САНАЛ**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнүүдийн гэрээний хугацаа, гэрээний сунгалт зэрэгт шинжилгээ хийхэд төсөл арга хэмжээг анх төлөвлөсөн хугацаанд нь гүйцэтгэсэн тохиолдол байхгүй, гэрээний хугацааг хэтрүүлэн ашиглалтад оруулсан байна гэжээ.

Дээрх төсөл арга хэмжээнүүд 2020 онд Улсын төсөвт батлагдсан бөгөөд дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлаас үүдсэн барилгын материалын үнийн өсөлт, цалингийн нэмэгдэл, тээврийн зардлын нэмэгдэл, ажиллах хүчний хомсдол зэрэг олон шалтгааны улмаас удааширч батлагдсан санхүүжилтээр барилга ашиглалтад орох боломжгүй нөхцөл үүссэнээс гэрээний хугацаанд ашиглалтад ороогүй. Мөн төсөвт өртгийн нэмэгдлүүд 2022 онд батлагдаагүй шалтгаанаар төсөл арга хэмжээний ашиглалтад орох хугацаа удааширсан байдалтай байна. Мөн тухайн жилд УИХ-аас төсөв батлахдаа санхүүжилтийг хэт бага баталж он дамжуулдаг байдал нь гэрээний хугацаанд барилга ашиглалтад орохгүй байхад нөлөөлж байна. Гэрээний хугацааг төсвийн тухай хуультай уялдуулж сунгаж байгаа тул энэ хэсгийн дүгнэлтийг хасуулах саналтай байна.

Мөн гэрээний хугацааг барилгын барьцаа хөрөнгийн дансанд хөрөнгө байршуулсан тохиолдолд сунгаж байгаа нь үндэслэлгүй байна гэжээ.

Барьцаа хөрөнгийн дансанд санхүүжилт байршуулах шийдвэрийг ЗГ-аас гаргадаг бөгөөд ЗГ-ын тогтоолд хугацаа зааж өгсний дагуу гэрээний хугацааг тус тогтоолтой уялдуулж гэрээнд тусгаж өгдөг.

Захиалагч талаас тавих хяналт хангалтгүй, гэрээний хугацаанд гүйцэтгүүлэх ажил дутмаг, гэрээний үүргийн биелэлтээ хангаагүй хуулийн этгээдэд хариуцлага тооцох арга хэмжээ авч ажилладаггүй нь захиалагч, гүйцэтгэгч нар бие биеэсээ хараат бус, ашиг сонирхлын зөрчилтэй байгааг харуулж байна гэжээ.

Захиалагч нь хяналт тавих чиг үүргээ аймгийн ГХБХБГ-аар гүйцэтгүүлдэг бөгөөд шаардлагатай үед давхар хяналтыг хэрэгжүүлж байна. Ковид-19 цар тахлаас үүдсэн эдийн засгийн хүндрэлээс хамаарч нэмэлт санхүүжилт Улсын төсөвт тухайн ондоо батлагдаагүй шалтгаанаас гэрээний хугацаанд ашиглалтад орохгүй нөхцөл байдал үүсэж байна. Энэ нь гүйцэтгэгчид хариуцлага тооцох үндэслэл болохгүй байгаа тул Захиалагчийн зүгээс гүйцэтгэгч нарт албан шаардлага болон, гэрээний үүргээ биелүүлэхийг шаардаж бодит гүйцэтгэлд

27

үндэслэн санхүүжилтийг олгож байгаа нь ашиг сонирхлын зөрчил үүсээгүй гэж үзэх үндэслэл болж байгаа тул энэ хэсгийн дүгнэлтийг хасуулах саналтай байна.

Барилгын ажлын гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналт хангалтгүй, улсын комиссоос өгсөн үүрэг даалгавар хэрэгжээгүй байна гэжээ.

Захиалагчийн хяналтыг аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлаг болох ГХБХБГ-ын БХБХ-ийн инженерүүд хяналтыг хэрэгжүүлж Улсын комисст хүлээж авах ажлыг зохион байгуулж байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын ХБТХОХ-ээс барилгын ажил бүрэн дуусч хяналтын үед өгсөн үүрэг даалгавар бүрэн биелэгдсэн, техникийн комиссоос өгсөн үүрэг даалгавар биелэгдсэн нөхцөлд Улсын комисс ажиллаж хүлээж авч байх талаар чиглэлийг удаа дараа өгч ажиллаж байна.

Батлагдсан төсөл арга хэмжээний анхны төсөвт дахин магадлал хийлгүүлж, төсөв нэмэгдүүлдэг байдал хэвийн үзэгдэл болсон байна гэжээ.

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлаас үүдсэн эдийн засгийн хямрал, бүх төрлийн зардал нэмэгдсэн шалтгааны улмаас төсөвт дахин мэргэжлийн экспертүүд магадлал хийж Үндэсний аудитын газраар хянуулсны дараа Улсын төсөвт нэмэлт санхүүжилт тусгагдаж байгаа тул энэ хэсгийн дүгнэлтийг хасуулах саналтай байна.

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

78



**ЗАВХАН АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР**

81090 Улаанбаатар, Завхан аймаг
Утас/Факс: 7046-26-20
И-мэйл: zavkhan@gazar.gov.mn

2024.04.18 № 137
таний 2024.04.15 -ны № 272

**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит
хийсэн тайлантай танилцлаа.

Уг аудитаар илэрсэн алдаа зөрчилтөө
холбоотой саналыг хавсралтаар гарган хүргүүлж
байна.

Хавсралт...//...хуудастай.

ДАРГА Д.АНХТЭС



812402203

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын 2024 оны 04-р сарын 18-ны өдрийн
13-дугаар албан бичгийн хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ ХИЙСЭН ТАЙЛАНД ӨГӨХ САНАЛ

2024.04.17

Д/д	Ажлын нэр	Илэрсэн зөрчил	Санал
1	Сонгино суманд баригдсан 320 хүүхдийн хичээлийн байр, спорт заалны барилга	Гүйцэтгэгчийн төлөөлөл, комиссын гишүүд дахин ажиллаж өмнө өгсөн үүргийн биелэлтийг шалгаж шаардлагатай зарим ажлыг гүйцэтгэгчээр засварлуулах, барилгын зураг төсөв, ил далд ажлын акт баримт материалыг ашиглагчид хүлээлгэн өгөх нь зүйтэй гэж үзлээ.	Комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 2023 оны 7 сард манай газарт ирүүлсэн. Ашиглалтын явцад гарч байгаа элдрэл гэмтлийг баталгаат хугацаанд тухай бүр гүйцэтгэгч Харгант ХХК засварлуулж байгаа байна. Иймд комисс дахин ажиллаж шаардлагагүй. Дутуу ажлыг хийж гүйцэтгүүлэх тухай 2024 оны 03 сарын 27-ны өдрийн 111 тоот албан бичгийг хүргүүлсэн болно.
2	Тэлмэн суманд баригдсан 320 хүүхдийн хичээлийн байр, спорт заалны	Биеийн тамирын заалны барилгын хучилт нимгэдсэнээс дээврийн дулаан алдагдал их цанталт үүссэн. Барилгын суурийн хаявч тойруулан хийсэн өнгөлгөө зарим газарт ховхорч унасан, цоох хагарсан барилгын гадна бохирын цооног дүүрч байгаагай уялдуулан усны хэрэглээг хязгаарлаж бие засах газрууд хэвийн ажиллах боломжгүй болж байгаа зэрэг зөрчлүүд байна. Бохирын цооногийг шингээлтгүй металл емкосоор хийсэн нь шаардлага хангахгүй, зурагт тусгагдсан 140 м3-ын багтаамжтай цооног материалыг хийцээс зөрүүтэй байна. Иймд дээрх зөрчлийг засаж, гадна бохирын шугамын өөрчлөлтийг хийж, цооногийг 40 м3-ын шингээлттэй цооног болгон өөрчилж хийлгүүлэх нь зүйтэй гэж үзлээ.	Биеийн тамирын заалны хучилтыг өөрчилсөн хэсэгт авторын зөвшөөрөл авсан дулаан техникийн тооцоог дахин хийлгэсэн. Гадна бохирын цооног ажлын төсөвт емкосоор гэж тусгагдсан байгальд бохир ус шингэх боломжгүй тул ул нь битүү хийхээр зурагт тусгагдсан байна.
3	Тосонцэнгэл суманд баригдсан 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга	Гадна дээврийн ус зайлуулах хоолойг ф150-ын хоолой болгож өргөсгөөгүйгээс ус хальж хөлдсөн, барилгын суурийн эргэн тойрон хийсэн хавтан өнгөлгөө зарим газарт ховхорч унасан, гадна хаалганы саравч хийгээгүй, гадна цэвэр усан хангамжийн худгаас ирж байгаа хэсэгт хөлдөлт үүссэн, урлагийн танхимын үзэгчдийн хэсэгт нэг гэрэлтүүлэг дутуу, шалны худгаасыг наах	Гадна дээврийн ус зайлуулах хоолойг ф150-ын хоолой болгож өргөсгөөгүйгээс ус хальж хөлдсөн, барилгын суурийн эргэн тойрон хийсэн хавтан өнгөлгөө зарим газарт ховхорч унасан, гадна хаалганы саравч хийгээгүй, гадна цэвэр усан хангамжийн худгаас ирж байгаа хэсэгт хөлдөлт үүссэн, урлагийн танхимын үзэгчдийн хэсэгт нэг гэрэлтүүлэг дутуу, шалны худгаасыг наах

		байгаа хэсэгт хөлдөлт үүссэн, урлагийн танхимын үзэгчдийн хэсэгт нэг гэрэлтүүлэг дутуу, шалны худгаасыг наах зэрэг ажлууд хийгдээгүй, техникийн иж бүрэн баримт бичгийг ашиглагчид хүлээлгэж өгөөгүй байна.	зэрэг ажлууд хийгдээгүй, техникийн иж бүрэн баримт бичгийг ашиглагчид хүлээлгэж өгөөгүй зэрэг ажлуудыг улсын комиссын үүрэг даалгавар хугацаатай үүрэг өгсөн.
4	Идэр сумын Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал	Төсөл арга хэмжээг гэрээний хугацаанд ашиглалтад оруулах боломжтой байсан гэж үзлээ. Учир нь тус барилгын санхүүжилтийг барилгын гүйцэтгэлд үндэслэн олгоогүй. 2022 онд санхүүжилтийг илүү олгосон, 2023 онд материалын үнийн зөрүүний 55 хувийг олгосон байна.	Сургуулийн барилгын ажлын явцад Ковид-19 цар тахлын улмаас хил гааль хаагдсан тулш шатахуундээвэр барилгын материалын үнийн өссөн. Мөн 2021 оны 01 сараас барилгын ажиллах хүчний зардал өссөн зэрэг шалтгаанаас гэрээт хугацаанд ашиглалтад ороогүй. Цаашид барилгын ажиллах хүчний зардлын зөрүүг тооцож төсөвт тусгуулах арга хэмжээ авч ажиллах.
5	Асгат суманд баригдаж буй 75 ортой дотуур байрны барилгын.	ажлыг 2021 оны 11 сарын 01-ны өдөр хүлээлгэн өгөхөөр анхны гэрээг хийсэн ч хэтрүүлсэн, цаашид тухайн барилга ашиглалтад орох эсэх нь тодорхойгүй байдалтай байна.	Ажиллах хүчний зардал нэмэгдсэн холбоотой нэмэлт санхүүжилтыг шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллах тал дээр дэмжлэг үзүүлэх
6	Соёлын төвийн барилга, 200 суудал /Нөмрөг сум/	Ашиглагчийн төлөөлөлтэй газар дээр нь уулзаж ярилцахад барилга дотор номын сангийн зориулалттай өрөө тасалгаа байхгүй. Зөвхөн Соёлын төвийн барилга нь баригдахаар төлөвлөгдсөн. Зураг төсөвт гадна тохижилт ер тусгагддаггүй гэж танилцуулсан.	Соёлын төвийн гадна тохижилт, ханын өөрчлөлт, тайзны технологи тоног төхөөрөмжийн ажлын зураг төсөв хийгдсэн бөгөөд 2024 оны улсын төсөвт тусгагддаггүй. Иймд хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх тал дээр холбогдох газар хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.
7		Барилгын ажлын гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналт хангалтгүй, улсын комиссоос өгсөн үүрэг даалгавар хэрэгжээгүй байна	Захиалагчийн техник хяналтыг тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна. Барилгын ажилд хяналт хийхэд ажлын талбайд журнал байхгүй үед албан тоотой илэрсэн зөрчлийг хүргүүлдэг. Төгс хурц консалтинг ХХК-д 2023 оны 08-18-ны өдөр хяналт хийсэн талаар 2023.08.21-ний өдрийн 372 тоотой, Тангарийн дэмдэг ХХК-д 2023.10.05-ны өдөр хяналт хийсэн талаар 2023.10.09 өдрийн 445 тоотой, Пирамид проект ХХК-д 2023.05.01-ний өдрийн 175 тоот, 2023.08.02 өдрийн 344 тоот, 2023.08.10 өдрийн 361 тоот, Эко энержи ресурс ХХК-д барилгын ажлыг эхлүүлэх талаар 2023.06.02-ны өдрийн 240 тоот, 2023.08.02 өдрийн 346 тоот албан бичгийг тус тус хүргүүлсэн. Мөн ажлыг эрчимжүүлэх, хүн хүчийг нэмэгдүүлэх гэрээт хугацаанд дуусгах талаар 2023 оны 08 сарын 01-с 09 сарын дуустал угсаар холбогдож шаардан ажилладаг ба ярьсан өдрийн тэмдэглэлийн дэвтэр нээн тэмдэглэл хөтлөн ажилласан. 2023 онд амийгий

			100 жилийн ой угтсан бүтээн байгуулалтын ажилтай байсан тул 2023 оны 07-р сард барилга угсралтын ажилд явцын хяналт хэрэгжүүлэх ажил хойширсон болно.
8		Асгат сумын 75 хүүхдийн дотуур байр, Нөмрөг, Түдэвтэй сумдын соёлын төвийн барилга, Идэр сумын 320 хүүхдийн сургуулийн байранд өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангалтгүй, өгсөн үүрэг даалгавраа эргэж хянаагүй	Нөмрөг, Түдэвтэй сумдын соёлын төвийн барилга, Идэр сумын 320 хүүхдийн сургуулийн байранд өгсөн үүрэг даалгаврын биелэлт ажлын талбайд хийгдсэн. Ажлын журналд биелэлтийг тооцсон тэмдэглэл хөдлөөгүй тул нөхөж хөтлөх ажлыг хэрэгжүүлнэ.
9		Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд ашиглалтад хүлээн авсан Тэлмэн, Сонгино сумдын 320 хүүхдийн сургууль, Тосонцэнгэл сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн ажлыг хүлээж авах ажлын хэсэг нийт 74 үүрэг даалгаврын биелэлт өгсөн боловч одоог хүртэл үүрэг даалгаврын биелэлтийн гүйцэтгэл хангалтгүй	2023 онд ашиглалтад хүлээн авсан Тэлмэн, Сонгино сумдын 320 хүүхдийн сургууль, Тосонцэнгэл сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн ажлыг хүлээж авах ажлын хэсгээс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 2024 оны хавар хийхээр хугацаатай үүрэг өгсөн 6-р сарын 1 дотор биелэлтийг бүрэн хангуулан ажиллана.
10		Тэмцээн уралдаанд оролцсон албан хаагчдад 4.2 сая төгрөгийн томилолт олгосон	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар нь газрын удирдлагын хэлтэс, барилга хот байгуулалтын хэлтэс гэсэн 2 нэгжтэй үйл ажиллагаа явуулдаг ба ГЗБГЗЗГ-с зөвшөөрөл өгсөний дагуу хяналтын зардлаас гарсан болно.
11		Газрын даргын албан хэрэгцээний автомашинь засвар үйлчилгээнд 35.0 сая төгрөг	Байгууллагын албан хэрэгцээнд 2 авто машин үйлчилгээнд явдаг ба барилгын техник хяналт, газрын ажлаар хөдөө сумдаар байнгын ажилладаг. Иймд мэргэжилтнүүдийн аюулгүй зорчих, машины бүрэн бүтэн байдлыг хангуулах засвар үйлчилгээг тогтмол хийж ажилладаг болно.
12		Байгууллагад 19.0 сая төгрөгийн техник хэрэгсэл худалдан авсан	2022 онд Архивын улсын шалтгалтаар нягтруулсан шүүгээнд архивын баримт бичгийн хадгалах стандартыг хангуулах чиглэл өгсөн. Иймд архивын тавьсан шаардлагын дагуу стандартын шүүгээ авч албан хэрэгцээнд ашиглаж байна.
13		Байгууллагын гадна тохижилт хайс хэмжаалтад 23.5 сая төгрөг, нийт 81.7 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулжээ.	Аймгийн 100 жилийн ойн хүрээнд Улиастай суманд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд гадна өнгө үзэмж, орчны тохижилтыг хийх аймгийн Засаг даргын захирамж гарсаны дагуу орчны тохижилт хийх ажилд 23.5 сая төгрөгийн гадна тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Иймд дээрх гарсан зардалд зориулалтын бусаар ашигласан гэж үзэхгүй байгаа тул акт тогтоолгохгүй байх саналыг гаргаж байна.

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР


81

Төрийн аудитын газрын тайлбар:

Аймгийн Засаг даргаас 5, ГХБХБГ-аас 13 санал ирүүлснийг хянаж нийт 4 саналыг хүлээн авч аудитын тайлангийн холбогдох хэсэгт найруулгын өөрчлөлт хийн, 14 саналыг хүлээн авах үндэслэлгүй тул тайланд өөрчлөлт оруулаагүй болно.

Санал	Тайлбар
Аймгийн Засаг дарга	
1	Ирүүлсэн тайлбар тодруулга нь хангалттай нотлох баримтаар дэмжигдэхгүй, Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас хойш төсөл арга хэмжээг гүйцэтгэх боломжтой хугацаа байсан гэж үзсэн тул аудитын тайланд өөрчлөлт хийгдээгүй
2	Аудитын тайлангийн Б.1 хэсэгт утга найруулгын өөрчлөлт хийсэн.
3	Аудитын тайлангийн Б.1 хэсэгт утга найруулгын өөрчлөлт хийсэн
4	Хангалттай, үндэслэлтэй тайлбар ирүүлээгүй тул саналыг хүлээн авах боломжгүй
5	Аудитын тайлангийн дүгнэлт хэсэгт утга найруулгын өөрчлөлт оруулсан
Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар	
1-9	Аудитын тайланд тусгагдсан асуудалтай утга агуулга төстэй саналыг ирүүлсэн тул тайланд өөрчлөлт хийгдээгүй .
10	Хангалттай нотлох баримтаар дэмжигдээгүй тул саналыг хүлээн авах боломжгүй
11	Ирүүлсэн нотлох баримт, тайлбарыг үндэслэн зөрчлийн жагсаалтад өөрчлөлт оруулсан
12	Аймгийн ТЕЗ-ийн төсөвт зохицуулалт хийх эрх Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт байхгүй тул саналыг хүлээн авах боломжгүй
13	Хангалттай нотлох баримтаар дэмжигдээгүй тул саналыг хүлээн авах боломжгүй

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА